



Хэвлэлийн мэдээ

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 11 дүгээр хуралдааны тухай 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн 11 дүгээр хуралдаан өнөөдөр Төрийн ордны “А” танхимд боллоо. Хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд оролцож, Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлан болон бусад асуудлуудтай танилцлаа.

ОУИТБС нь байгалийн баялгаас (ашигт малтмал, газрын тос, уран) бий болж буй орлогын ил тод байдлыг хангах замаар сайн засаглалыг бэхжүүлэх, орлогын зохистой менежментийг хөгжүүлэхэд зорьж ажилладаг бөгөөд энэ зорилтын хүрээнд уул уурхай, газрын тос, ураны компаниудын улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрийг, тэдгээр компаниудаас Засгийн газрын хүлээн авсан орлогын ил тод байдлын тайланг хүлээн авч, хоёр талын тайланг хөндлөнгийн, олон улсын аудитаар баталгаажуулж Монгол Улсын нэгтгэл тайланг 2007 оноос жил бүр гаргаж байна.

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлдэг бөгөөд төр, компани, иргэний нийгмийн тэнцүү төлөөлөлтэй. Жил бүрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар Санаачилгын жил бүрийн нэгтгэлийн тайланг хэлэлцэн, батлаж, нийтэд ил тод мэдээлдэг уламжлалтай.

2012 онд ОУИТБС-ын тайланг 1531 компани гаргаж, үүнээс 200 компанийн тайланг аудитаар тулган баталгаажуулж улсын төсөвт **1 их наяд 594 тэрбум төгрөгийн** татвар, төлбөр төлснийг буюу улсын төсвийн урсгал орлогын 33 хувийг бүрдүүлснийг нотолсон юм.

Аудитын нэгтгэлд хамрагдсан 200 компаниас топ 10 компани л дээрх нэгтгэлийн дүнгийн 80 хувийг бүрдүүлсэн байна. Үүнд: **Эрдэнэт үйлдвэр ХХК-32,6%**, **Оюу толгой ХХК-12,7%**, **Энержи ресурс ХХК-7%**, Петрочайна дачин тамсаг ХХК-6,6%, Монголын алт МАК ХХК-5,4%, Эрдэнэс МГЛ ХК-5%, Таван толгой ХК-3,7%, Эрдэнэс таван толгой ХК-2,6%, Болд төмөр ерөө гол ХХК-2,4%, Саусгоби сэндс ХХК-2,4% зэрэг болно. Харин татварын нэр төрлөөр нь авч үзвэл олборлох компаниудын төлсөн нийт төлбөрийн 32%-ийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр (роялти) дангаар бүрдүүлжээ.

Засгийн газрын хүлээн авсан дүн, компанийн төлсөн дүнг тулган шалгахад 2012 онд 360,9 сая төгрөгийн тайлбарлагдаагүй цэвэр зөрүү үүссэн бөгөөд зөрүү бүрийн шалтгааныг нэгтгэлийн тайланд тодорхой дурьдсан байна. Холбогдох компани, төрийн байгууллагууд зөрүүний тайлбараа 2014 он 1 дүгээр сарын 31-ний дотор нийтэд мэдээлэх нь зүйтэй гэж ОУИТБС-ын Ажлын хэсгийн зүгээс онцолжээ.

Энэ удаагийн аудитын нэгтгэлийн ажил мэргэжлийн өндөр түвшинд хийгдэж, дан ганц төлбөр, орлогыг нэгтгэн баталгаажуулахаас гадна олборлох компаниудын орон нутгийн захиргаатай байгуулсан гэрээ, уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн талаар хөндлөнгийн дүгнэлт өгч, Монгол Улс цаашид байгалийн баялгаас орж буй орлогыг бүрэн нягтлах, орлого менежментийн засаглалыг сайжруулах чиглэлээр үнэтэй зөвлөмжүүдийг өгсөн болно.

Түүнчлэн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар 2012 оны нэгтгэлийн тайлангаас гадна Санаачилгын 2013 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2014 оны ажлын төлөвлөгөөний төсөл, Санаачилгыг орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий Дэд зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийн төслийг хэлэлцэн баталлаа.

Монголын ОУИТБС ажлын алба

Дэлгэрэнгүйг: www.eitimongolia.mn цахим хуудаснаас

Утас: 70110525